



**НИЙСЛЭЛИЙН
АГААРЫН БОХИРДЛЫГ БУУРУУЛАХ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2018 оны 12 сарын 17 өдөр

Дугаар А/68

Улаанбаатар хот

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Агаарын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1, 8.1.4, 8.1.5, Байгаль орчин, ногоон хөгжлийн сайд /хуучин нэрээр/-ын 2014 оны А/181 дүгээр тушаалаар батлагдсан “Агаарын бохирдлын эх үүсвэрийн улсын нэгдсэн тоо бүртгэл явуулах журам”, Нийслэлийн Засаг даргын 2018 оны А/945 дугаар захирамжийг үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн Засаг даргын Ногоон хөгжил, агаарын бохирдол хариуцсан орлогчийн баталсан “Агаарын бохирдлын эх үүсвэрийн улсын нэгдсэн тоо бүртгэл явуулах ажлын удирдамж”-д заасан дүүргүүдийн хорооны зохион байгуулагч, хорооны хэсгийн ахлагч нарт олгох урамшуулал, бичиг хэргийн зардлыг хавсралтаар баталсугай.


2. Урамшуулал болон бичиг хэргийн зардалд гаргах нийт 77,356,000 /далан долоон сая гурван зуун тавин зургаан мянган/ төгрөгийг мөрийн хөтөлбөрийн зардлаас гаргахыг Ахлах нягтлан бодогч /О.Цэцэгмаа/-д зөвшөөрсүгэй.

ДАРГА



Б.ЦАЦРАЛ

Нийслэлийн Агаарын бохирдлыг бууруулах
Газрын даргын 2018 оны 12 дугаар сарын
17-ны өдрийн 1/68 дугаар тушаалын
хавсралт



ДҮҮРГҮҮДЭД ОЛГОХ УРАМШУУЛАЛ, БИЧИГ
ХЭРГИЙН ЗАРДАЛ

№	Дүүрэг	Хорооны зохион байгуулагчдад олгох урамшуулал	Хорооны хэсгийн ахлагчдад олгох урамшуулал	Тооллогын маягт хэвлэх зардал	Нийт
1	Багануур	280,000	1,736,000	500,000	2,516,000
2	Багахангай	112,000	336,000	200,000	648,000
3	Баянгол	448,000	3,920,000	800,000	5,168,000
4	Баянзүрх	1,120,000	17,080,000	2,000,000	20,200,000
5	Налайх	392,000	2,632,000	700,000	3,724,000
6	Сонгинохайрхан	1,288,000	13,608,000	2,300,000	17,196,000
7	Сүхбаатар	616,000	6,272,000	1,100,000	7,988,000
8	Хан-Уул	672,000	6,944,000	1,200,000	8,816,000
9	Чингэлтэй	728,000	9,072,000	1,300,000	11,100,000
	Бүгд	5,656,000	61,600,000	10,100,000	77,356,000